



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын НТАГ-2023/19-11-ШТА-ГА тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, үр дүнг 2024 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны нэгдүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс /Э.Мөнхмандах/-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт тус тус хүргүүлсүгэй.




М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР





ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө бага, үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.



АУДИТЫН СЭДЭВ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

Улаанбаатар хот
2023 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	3
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	4
Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс	Хавсралтын жагсаалт	4
Хэлтсийн дарга:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
 Э.Мөнхмандах	Бүлэг 1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж байна уу?	6
Аудитын менежер:	1.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна уу?	6-11
Ахлах аудитор:		
 Б.Билэгт		
Аудитор:		
 Д.Жаргалан		
 М.Номин-Эрдэнэ	Бүлэг 2. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байна уу?	12
	2.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байна уу?	13-21
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787	2.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарч байна уу?	21-26
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	2.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?	26-32
	Аудитын дүгнэлт	33
	Аудитын зөвлөмж	34
	Хавсралт	35-36

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БЗД	Баянзүрх дүүрэг
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НЭ	Нэгдсэн эмнэлэг
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМД	Нийгмийн эрүүл мэндийн даатгал
НТТТ	Нийслэлийн түргэн тусламжийн төв
НШЭНТ	Нийслэлийн шүд эрүү нүүрний төв
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ОХБ	Оношийн хамааралтай бүлэг

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа	7
Хүснэгт 2	Дэлхийн бусад улс орнууд даатгалын систем	9
Хүснэгт 3	Дэлхийн улс орнуудын зардлын хувь	10
Хүснэгт 4	Дэлхийн улс орнуудын даатгалын тогтолцоо	10-11
Хүснэгт 5	Нэг иргэнээр тооцож олгох хэмжээ / Дотны туслагч ӨЭМТ/	13-14
Хүснэгт 6	ЭМДЕГ-аас ӨЭМТ-дэд олгосон санхүүжилт дүүргээр	14
Хүснэгт 7	ЭМБ-ын 2021 оны орлого, зарлагын гүйцэтгэл	15
Хүснэгт 8	ЭМБ-ын 2022 оны орлого, зарлагын гүйцэтгэл	15
Хүснэгт 9	ЭМБ-ын эмч нарын мэргэшлийн төрөл	17
Хүснэгт 10	Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын батлагдсан орон тоо	17
Хүснэгт 11	Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021-2022 онд олгосон санхүүжилт /НЭМГ-ын харьяа ЭМБ/	18
Хүснэгт 12	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020, 2021 он, 2022 оны гүйцэтгэл	20
Хүснэгт 13	БГДЭМТ-өөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо, мэдээ	20
Хүснэгт 14	2021-2022 оны Хүүхдийн эндэгдлийн тоо НЭМГ-ын харьяа ЭМБ-аар	21
Хүснэгт 15	Дүүргүүдийн дундаж хүн ам	22
Хүснэгт 16	ЭМБ-ууд иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлын тоо	25
Хүснэгт 17	ЭМДЕГ-аас 2021-2022 онд олгосон санхүүжилт, хасагдалт /ТӨЭМБ/	28
Хүснэгт 18	Нийслэлийн шүд, эрүү нүүрний төвийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үнэлгээний дүн	29
Хүснэгт 19	Харьяа ЭМБ-ын 2022 оны үнэлгээ	29
Хүснэгт 20	Нийслэлийн дотоод аудитын албанаас 2022 онд аудит, хяналт шалгалтад хамрагдсан ЭМБ-уудын дүн, мэдээ	30
Хүснэгт 21	Түүвэрт хамрагдсан ӨЭМТ-ийн 2022 оны гэрээний биелэлт	31
Хүснэгт 22	2021 оны шилэн дансны мэдээлэл	31-32
Хүснэгт 23	2022 оны шилэн дансны мэдээлэл	32

Графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	Эмч нарын мэргэшсэн байдал	16

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Нийслэлийн харьяа ЭМБ-уудын ашиглаж буй цахим системийн жагсаалт, танилцуулга	35-36

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Нийслэл дэх Төрийн Аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт	Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх; ○ Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад НЭМГ болон нийслэл, дүүргийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдээс түүвэрлэн 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг Төрийн Аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим” MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020, “МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга Э.Мөнхмандах удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Билэгт, аудитор Д.Жаргалан, М.Номин-Эрдэнэ нар гүйцэтгэв. Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэв.
Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл	Аудитын явцад шалгагдагч байгууллагаас баримт материал гаргаж өгөхгүй байх, судалгаа мэдээг дутуу гаргах зэрэг хүндрэл бэрхшээл үүсэж байсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УИХ-аас Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэж, иргэд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн тариф, шалгуурыг оновчтой болгох ажлууд хэрэгжиж эхэлсэн байна.

Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олон улсын эмнэл зүйн удирдамжид үндэслэн оношийн хамааралтай бүлгээр нэхэмжлэх эмчилгээ, үйлчилгээний тарифыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 03 болон 04 дүгээр тогтоолоор баталсан байна.

Монгол Улсад дараах эрүүл мэндийн дараах тусламж, үйлчилгээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;
- Эх барихын тусламж, үйлчилгээ;
- Яаралтай тусламж, үйлчилгээ;
- Түргэн тусламжийн үйлчилгээ;
- Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;
- Сэргээн засах тусламж, үйлчилгээ.

Монгол Улсад эрүүл мэндийн салбар дараах бодлогын баримт бичгүүд салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна байна. Үүнд :

- Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого
- Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого
- Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө
- Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлого
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого

УИХ-аас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хийх хууль эрх зүйн орчныг бий болгож Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуулийн өөрчлөлтөөр эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн тогтолцоогоор дамжсан шинэчлэлийг эхлүүлсэн бөгөөд дараах 6 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Улсын төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн салангид үр ашиггүй эх үүсвэрүүдийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, нэг худалдан авагчийн тогтолцоод шилжүүлэх;
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн даатгуулагчдад үзүүлэх санхүүгийн хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн дээд хязгаарыг хүчингүй болгох;
3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг хянах, үнэлэх тогтолцоог бий болгож, санхүүжилттэй уялдуулах;
4. Эмийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, чирэгдлийг арилгах;
5. Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлж, чирэгдлийг арилгах;
6. Ажлын гүйцэтгэлтэй уялдсан цалин урамшууллын тогтолцоог бий болгох;

Уг шинэчлэлийн хүрээнд 2021 оноос улсын төсвөөс шууд эмнэлэгт татаас хэлбэрээр санхүүжилт олгохоо больж санхүүжилтийг төсвийн жилийн эхэнд эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй

тусламж, үйлчилгээний нэр төрлийг тогтоож, түүний өртөг зардлыг тооцож оношийн хамааралтай бүлэг бүрд тариф тогтоож, санхүүжүүлж байна.

Түүнчлэн 2022 оноос анхан шатны тусламж, үйлчилгээ нь Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн хэлбэрээс гарч Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хуулийн өөрчлөлт батлагдсанаар гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн юм.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу анхан шатны суурь тусламж, үйлчилгээг нэг иргэнээр тооцон төлбөрийн хэлбэрээр, зарим төрлийн оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрийн тусламж үйлчилгээг тохиолдол бүрд төлбөр олгох хэлбэрээр, яаралтай түргэн тусламж, шүдний тусламж үйлчилгээг лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг санхүүжүүлж буй ОХБ-ийн санхүүжилтийн аргаар тус тус санхүүжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Эрүүл мэндийн даатгалын сангийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал батална.*” гэж заасны дагуу 2021 онд орлогыг 951.3 тэрбум, зарлагыг 1,210.7 тэрбум, 2022 онд орлогыг 1,450.7 тэрбум, зарлагыг 1,481.4 тэрбум төгрөгөөр тус тус баталжээ.

ЭМДҮЗ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.1-д “*эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдээдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;*” гэж заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагыг төлөвлөж, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталдаг байна.

ЭМДҮЗ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6-д “*эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах;*”, 14.8.7-д “*даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах;*” эрхтэй гэж заасны дагуу хяналтын журам, шалгуурыг ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоол, 2022 оны 12 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д “*Монгол Улсын иргэний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний дараах төлбөрийг төр хариуцна;*”, 24.6.10-т “*эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ*” гэж заасны дагуу 2022 оны Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний 2.1.2-т “*төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80%-ийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгон, үлдээгдэл 20%-ийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн сар бүрийн гэрээний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн олгох эсэхийг шийдвэрлэх*” гэж заасан байна.

БҮЛЭГ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДАХГҮЙ БАЙНА.

1.1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд тусгасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой арга хэмжээнүүд уялдаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоондоо шинэчлэлт хийж байгаа ч хэрэгжилт хангалтгүй, НЗД нийслэлийн эрүүл мэндийн салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлаагүй байна.

1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд хөгжлийн бодлого төлөвлөлтөд нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчмуудыг баримтлахаар тусгасан ба 6 дугаар зүйлийн 6.7¹-д заасны дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан.

1.3. Үүний дагуу НИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №02/09 дугаар тогтоолоор “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг баталж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдолтой 7 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөсөн байна. “Монгол улсын хөгжлийн 2021 оны төлөвлөгөө”-г батлаагүй шалтгаанаар НИТХ “Нийслэлийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө”-г батлаагүй.

1.4. НИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11/31 тоот тогтоолоор “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг” баталсан бөгөөд 2022 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар НЗДТГ-аас тус төлөвлөгөөнд НЭМГ-аас хариуцах арга хэмжээнд хийсэн хяналт шинжилгээгээр 67,7 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа

“Алсын хараа -2050”	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”
<p>Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлж 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Урт хугацааны хөгжлийн бодлогын 1 үе шат нь 2020- 2030 онд хэрэгжүүлэхээр “Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе” гэж нэрлэн дараах үндсэн 4 чиглэлийг баталсан байна. Үүнд :</p> <p>Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн/нийтийн эрүүл мэнд/ тусламж үйлчилгээний үндэсний тогтолцоо бүрдүүлэх</p> <p>Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшилийг нэвтрүүлж, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо бүрдүүлэх</p> <p>Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх</p>	<p>“Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.</p> <p>Нийт 8 зорилтыг дэвшүүлсэн.</p>	<p>“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>“Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг уртасгахад оршино”</p>

¹ Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.”

1.5. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд давхардсан тоогоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой нийт 44 /давхардсан тоо/ арга хэмжээ тусгагдсан.

1.6. Эдгээр арга хэмжээний хүрээнд халдварт бус өвчний эрт илрүүлэг-оношилгоо, эмчилгээг сайжруулах, бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэх, үзлэг шинжилгээг тогтмол зохион байгуулах, стандартын шаардлага хангасан байртай ӨЭМТ-ийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулах чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээнүүд “Алсын хараа 2050”, “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол улсын 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдтэй уялдсан байна.

1.7. Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1д заасны² дагуу Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг 4 жилээр боловсруулах шаардлагатай ч “Нийслэлийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г батлаагүй байна.

1.8. “Нийслэлийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдолтой 7 зорилт бүхий 22 арга хэмжээ төлөвлөгдсөн. Үүнээс 20 арга хэмжээ хэрэгжсэн байна. Тухайлбал:

- Нийслэлийн хэмжээнд 2022 оны байдлаар халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт давхардсан тоогоор нийт 1386422 хүн хамрагдсан байна. Энэ нь 2021 оны статистик тооноос 266421 хүнээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.
- БЗДХ илрүүлэх үзлэг, шинжилгээ, эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг 72369 хүнд хийж тэмбүүгийн 542 зааг хүйтэн нийт 464, трихомониаз нийт 541 тохиолдлыг илрүүлэн бүрэн эмчилсэн. БЗДХ/ДОХ - ын хавьтлын илрүүлэг өмнөх онтой харьцуулахад 6 хувиар нэмэгдсэн.
- Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс Эрүүл мэндийг дэмжих төв тус тус байгуулан үйл ажиллагааг эхлүүлжээ.

Дутуу хэрэгжилттэй арга хэмжээний хувьд :

- Засгийн газрын санаачлагчаар “Эрүүл мэнд - Үндэсний баялаг” урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийг 2022 оны 05 дугаар сарын 01 -ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01 -ний хооронд зохион байгуулж байна. Нийслэлийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт хамрагдвал зохих 1602904 иргэн хамрагдахаас 398767 хүн хамрагдаж хамрагдалтын хувь 24,8% байна.

² Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна.

- 2.1.6.4-д Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, чадлыг сайжруулах ажлыг төлөвлөсөн ч санхүүжилттэй холбоотойгоор хугацаа хоцорсон. Тухайлбал :
 - Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Хан -Уул дүүргийн 14 дүгээр хороо 2021 -2022 онд 1,337.9 сая төгрөг, Өрхийн Эрүүл мэндийн төвийн барилга /Хан -Уул дүүргийн 16 хороо/, Хан -Уул дүүргийн 8 хороо/-нд шинээр барих 2022 -2023 онд 1,600.0 сая төгрөгөөр тус тус барихаар төсөв батлагдсан. Тус төсөл арга хэмжээ нь 2022 оны 10 дугаар сарын 28 -ны өдрөөс барилгын ажлыг эхлүүлсэн байна.

Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдолтой зорилт арга хэмжээнүүд уялдаж байгаа хэдий ч НЭМГ нийслэлийн эрүүл мэндийн салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулаагүй байна.

1.9. УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор ЭМДҮЗ-ийг байгуулж, гишүүдийг томилсон. “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн 14 дүгээр³ зүйлд ЭМДҮЗ-ийн чиг үүргийг тодорхой зааж өгсөн.

1.10. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг үндэслэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-г баталсан. Энэхүү тогтоолын 4⁴-т хөнгөлөлттэй эмийн жор бичих эрх бүхий эмч нарт мөн тухайн эмийг бичих эрхтэй эмчийн ангиллын дагуу жор бичихийг зааж өгсөн.

1.11. “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-д эмийг бичих эрхтэй эмчийн ангиллыг тодорхой зааж өгсөн хэдий ч ӨЭМТ-ийн эмч нар ангилал харгалзахгүй эмийн жор бичиж байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-г батлах тухай 11 дүгээр тогтоолд заасан анхан шатны ЭМБ-ын эмч нар зөвхөн А ангиллын эмийг хөнгөлөлттэй бичих тухай заалт хэрэгжихгүй байна.

1.12. ДЭМБ эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог 3 бүрэлдэхүүн хэсэгт авч үздэг.⁵

1. Эрүүл мэндийн салбарын эх үүсвэрийг нэмэгдүүлэх буюу салбарт зарцуулах санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх
2. Салангид санхүүгийн эх үүсвэрүүд болох улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, хандивлагчдын санхүүжилт, дэмжлэг зэргийг нэг санд төвлөрүүлж, давхардлыг арилгаж, үр ашгийг нэмэгдүүлэх
3. Худалдан авах буюу бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зарчмаар хамгийн үр дүнтэй, үр ашигтай тусламж, үйлчилгээг даатгуулагчдын өмнөөс эрүүл мэндийн байгууллагуудаас чанарыг хянасны үндсэн дээр авах юм.

Хүснэгт 2. Дэлхийн бусад улс орнууд даатгалын систем

³ Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрдэнэ.

⁴ тогтоолын хавсралтаар баталсан жагсаалтад заасан эмийг ерөнхий нэршлээр бичиж байхыг хөнгөлөлттэй эмийн жор бичих эрх бүхий эмч нарт, мөн тухайн эмийг бичих эрхтэй эмчийн ангиллын дагуу жор бичихийг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх, худалдааны нэршлээр тогтоосон эмийн үнийн дээд хязгаараас хэтрүүлэхгүйгээр даатгуулагчид үнийн хөнгөлөлт үзүүлж байх

⁵ https://www.who.int/health-topics/health-financing#tab=tab_1/

Засгийн газраас санхүүждэг буюу нэг төлбөрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ч нэрлэдэг системтэй улсууд нийт улс орнууд:	Бүх нийтийн даатгалын тогтолцоотой улс орнууд:	Бүх нийтийн төр, хувийн хэвшлийн даатгалын тогтолцоотой улс орнууд:	Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой улсууд:	Бүх нийтийн бус даатгалын тогтолцоотой улс орнууд:
Австрали, Бутан, Канад, Куба, Дани, Финланд, Грек, Исланд, Ирланд, Итали, Кувейт, Малайз, Хойд Солонгос, Норвеги, Оман, Португал, Испани, Шри Ланка, Швед, Тайвань, Украин, Их Британ	Австри, Бельги, Болгар, Хятад (Хонконг, Макао), Хорват, Чех, Франц, Герман, Унгар, Иран, Энэтхэг, Япон, Латви, Литва, Монако, Монгол, Молдав, Польш, Орос, Сингапур, Солонгос	Алжир, Аргентин, Чили, Кипр, Мексик, Перу, Турк	Израиль, Лихтенштейн, Нидерланд, Швейцарь	Бангладеш, Бүгд Найрамдах Конго Улс, Египет, Этиоп, Индонез, АНУ, Йемен.

Эх сурвалж : Монгол банк, 2022 он

1.13. ЗГ-ын 2016-2020 онд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэн, иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, даатгуулагч бүр орлогын байдлаасаа үл хамааран аливаа санхүүгийн бэрхшээлгүйгээр, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар 2 дахин нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.⁶ Энэ хөтөлбөрийн хүрээнд БНСУ-ын туршлага дээр үндэслэн эрүүл мэндийн даатгалын тогтолцоондоо шинэчлэлт хийсэн байна.⁷

1.14. БНСУ-д эрүүл мэндийн даатгал нь албан журмын даатгалд хамаардаг. Эрүүл мэндийн даатгалтай холбогдох харилцааг эрүүл мэндийн даатгалын тухай хууль, хуулийг хэрэгжүүлэх журмаар⁸ зохицуулдаг. Үндэсний эрүүл мэндийн даатгалын алба нь даатгагдсан иргэдийг баталгаажуулан үнэмлэх олгож, эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан эрүүл мэндийн тэтгэмжийг олгоно. Ажил эрхлэгчдийн хувьд даатгалын төлбөрийн 50 хувийг ажил олгогч, үлдсэн 50 хувийг даатгуулагч өөрөө төлдөг.

УЛС ОРОН	Хүснэгт 3. Дэлхийн улс орнуудын зардлын хувь		
	ДНБ-Д ЭЗЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН ЗАРДЛЫН ХУВЬ %/	ЗГ-ЫН ЗАРДАЛД ЭЗЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН ХУВЬ %/	ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ ЗАРДАЛД ЭЗЛЭХ ХУВЬ ХҮНИЙ ТӨЛБӨР %/
ФРАНЦ	9.6	17.0	9.8
АВСТРИ	7.6	14.9	18.9
ЯПОН	9.1	23.4	13.5
НИДЕРЛАНД	8.4	19.3	11.5
ИХ БАРИТАНИ	7.8	18.9	15.1
БЕЛЬГИ	8.4	15.8	15.9
ХБНГУ	9.4	21.4	12.4
АНУ	14.0	39.5	11.1
ТАЙЛАНД	2.9	15.3	12.1
ФИЛИППИН	1.4	7.1	53.9
БНХАУ	2.9	9.1	35.9
МОНГОЛ	3.5	10.3	36.4
ВЬЕТНАМ	2.7	8.9	44.6

Эх сурвалж : Оношийн хамааралтай бүлэгт ангилал, өртгийн жин тооцох судалгааны тайлан ШУТИС, АХБ-ны Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх төсөл, 2021 он

1.15. УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаас холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт орж, төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээнүүдийг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах замаар Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь “Нэг худалдан авагч” болох эрх зүйн орчин бүрдсэн.

⁶ МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

⁷ [대한민국 영문법령 \(klni.re.kr\)](http://klni.re.kr)

⁸ Enforcement decree of the national health insurance

Хүснэгт 4. Дэлхийн улс орнуудын даатгалын тогтолцоо

УЛС ОРОН	ТӨЛБӨРИЙН АРГА	ХУДАЛДАН АВАГЧ	ЭМНЭЛГИЙН ЗАСАГЛАЛ, ӨМЧИЙН ХЭЛБЭР
ФРАНЦ	ОХБ	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Бие даасан төрийн болон хувийн
АВСТРИ	ОХБ	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Бие даасан төрийн болон хувийн
ЯПОН	ОХБ+ҮЙЛДЭЛ	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч /ЭМЯ тарифаар бодлого тодорхойлдог/	84% хувийн
НИДЕРЛАНД	ОХБ, Нэг иргэн	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Бие даасан төрийн болон хувийн
ИХ БАРИТАНИ	ОХБ, Нэг иргэн	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Хувийн
БЕЛЬГИ	ОХБ, Нэг иргэн	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Бие даасан төрийн болон хувийн
ХБНГУ	ОХБ, Нэг иргэн	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Бие даасан төрийн болон хувийн
АНУ	ОХБ+ҮЙЛДЭЛ	Хувийн даатгалын тогтолцоо, салангид худалдан авагч	Хувийн
ТАЙЛАНД	ОХБ	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Хувийн
ФИЛИППИН	ОХБ+ҮЙЛДЭЛ	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Хувийн
БНХАУ	Үйлдлээр төлөх	НЭМД тогтолцоо, салангид 3 эх үүсвэр	Бие даасан төрийн болон хувийн
МОНГОЛ	ОХБ, Нэг иргэн	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Төрийн болон хувийн
ВЬЕТНАМ	Үйлдэл, Нэг иргэн	НЭМД тогтолцоо, холимог худалдан авагч	Бие даасан төрийн болон хувийн

Эх сурвалж : Оношийн хамааралтай бүлэгт ангилах, өртгийн жин тооцох судалгааны тайлан, ШУТИС, АХБ-ны Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх төсөл

1.16. ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор нийт 563 оношны хамааралтай бүлгээр ЭМДЕГ-тай гэрээтэй төрийн өмчийн болон хувийн хэвшлийн ЭМБ-аас даатгуулагчдад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авч байна.

Иргэдийг санхүүгийн бэрхшээлгүйгээр, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон улсын туршлага дээр үндэслэн эрүүл мэндийн даатгалын тогтолцоондоо шинэчлэлт хийн ажиллаж байна.

БҮЛЭГ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ДААТГУУЛАГЧИЙН ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ БҮРЭН ҮЗҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

2.1. ЭМДС-ийн орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгуулах нэг иргэнээр тооцон олгох төслийг 2021, 2022 онд НЭМГ-аас албажуулан хүргүүлээгүй, ЭМДЕГ-аас 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн бүс нутгийн хүн амын тоотой уялдуулан бодитой хуваарилаагүй, эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан даатгалын гэрээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр бодитой дүгнээгүй, олгосон санхүүжилт хоёр дахин нэмэгдсэн ч дүүргийн эмнэлгүүдэд ирэх ачаалал буурахгүй байна.

2.2. НЭМГ-ын харьяа лавлагаа шатлалын ЭМБ-аас 2021 оны төсвийн төсөлд 69.7 тэрбум, 2022 оны төсвийн төсөлд 132.5 тэрбум төгрөгийн саналыг боловсруулан ЭМДЕГ-т ирүүлснийг 2021 онд 59.5 тэрбум, 2022 онд 132.5 тэрбум төгрөгөөр тус тус хянажээ.

2.3. Нийслэлийн анхан шатны ЭМБ-ын нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн төсвийг ӨЭМТ-үүд тухайн хорооны хүн амын тоог дүүргийн статистикийн хэлтсээс авч, хорооны засаг даргаар албажуулан санхүүжилтийн төсвийн төслийг дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлдэг байна.

2.4. Харин НЭМГ нь 2021, 2022 онд дээрх ӨЭМТ-өөс дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тооцоог нэгтгэн ЭМДЕГ-т ирүүлээгүй байна. Аудитын түүвэрт хамрагдсан ӨЭМТ-үүд нь 2022 оны 1 дүгээр сард ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний хавсралтаар нэг иргэнээр тооцож олгох тоо хэмжээ, төлбөрийн хэмжээг тусгасан байна.

2.5. Нэг иргэнээр тооцож олгох төлбөрийн хэмжээг ЭМДҮЗ-ийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нэмэгдүүлэн өөрчилсөн бөгөөд 2022 оны 1, 2, 3 дугаар сарын санхүүжилтийг шинэчилсэн хэмжээгээр нөхөж олгохоор заасан боловч тухайн онд бүрэн олгоогүй байна. Тухайлбал, СБД-ийн Дотны туслагч ӨЭМТ-д нэг иргэнээр тооцож олгох тоо хэмжээ, хуваарилах санхүүжилтийг ЭМДЕГ-аас олгосон санхүүжилттэй харьцуулахад 111.5 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

Хүснэгт 5. Нэг иргэнээр тооцож олгох хэмжээ / Дотны туслагч ӨЭМТ/

№	Тусламж, үйлчилгээний төрөл	ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан төлбөрийн хэмжээ, төгрөгөөр	2022 онд төлөвлөсөн тоо хэмжээ	Хуваарилах санхүүжилт	ЭМДЕГ-аас 2022 онд олгосон санхүүжилт	
А	1	2	3	4	5	6
1.1	0-5 нас	Гэр хороолол Орон сууц	106,632.0 92,414.0	1180 1181	125,825,760.0 109,140,934.0	
1.2	6-15 нас	Гэр хороолол Орон сууц	46,208.0 42,652.0	1394 1394	64,413,952.0 59,456,888.0	
1.3	16-49 нас эмэгтэй	Гэр хороолол Орон сууц	49,762.0 49,762.0	1926 1926	95,841,612.0 95,841,612.0	
1.4	60 дээш нас	Гэр хороолол Орон сууц	67,534.0 60,424.0	485 485	32,753,990.0 29,305,640.0	
1.5	Бусад	Гэр хороолол Орон сууц	39,098.0 35,544.0	2334 2334	91,254,732.0 82,959,696.0	
	Нийт				786,794,816.0	675,331,567

2.6. Санхүүжилтийг дутуу хуваарилсан нь ЭМДЕГ болон ӨЭМТ хоорондын байгуулсан 2022 оны гэрээ дүгнэх хугацаа өнгөрсөн, гэрээг дүгнэхэд ашиглах шалгуур үзүүлэлтийн дүн мэдээ гаргаагүй байгаа зэргээс шалтгаалсан байна.

ЭМДС-ийн орлого, зарлагын төлөвлөгөөг батлахдаа нэг иргэнээр тооцон олгох төслийг 2021, 2022 онд холбогдох байгууллагаас албажуулан аваагүй бөгөөд 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн бүс нутгийн хүн амын тоотой уялдуулан бодитой хуваарилаагүй байна.

2.7. ЭМДЕГ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч ӨЭМТ-дэд олгосон санхүүжилтийг тухайн онд бүрэн олгоогүй байхад жилийн эцэст хоёр талаас өглөг авлагагүйгээр тооцоо нийлж байгаа нь ЭМБ-ын нягтлан бодогч нар жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргах хугацаанд шахагддаг, санхүүжилттэй холбоотой асуултад ЭМДЕГ-аас хариулт авч чаддаггүй зэргээс шалтгаалж байна.

Хүснэгт 6. ЭМДЕГ-аас ӨЭМТ-дэд олгосон санхүүжилт дүүргээр

№	Дүүрэг	2022 онд санхүүжилт авсан ӨЭМТ-ийн тоо	Монгол улсад оршин суугаа хүн амын тоо		2022 онд ӨЭМТ-д олгох нийт санхүүжилт /сая.төг/		Үүнээс нэг иргэнээр тооцож олгох санхүүжилт /сая.төг/	
			2020	2021	Олгохоор тооцсон	Олгосон санхүүжилт	Олгохоор тооцсон	Олгосон санхүүжилт
А	1	2	3	4	7	8	9	10
1	БНД	4	29,342	29,433	1,839.2	2,148.9	1,292.8	1,292.8
2	БГД	21	231,517	236,385	13,339.6	15,047.8	10,109.3	10,109.3
3	БЗД	26	367,679	383,892	21,451.2	24,640.7	15,745.9	15,745.9
4	НД	4	38,690	38,929	2,423.8	2,815.0	1,762.1	1,762.1
5	СХД	27	335,703	341,540	17,971.8	20,157.0	14,964.6	14,964.6
6	СБД	16	144,616	144,542	8,342.5	9,486.9	6,416.5	6,416.5
7	ХУД	15	195,927	209,524	12,422.7	14,196.6	8,577.3	8,577.3
8	ЧД	16	151,203	150,548	8,746.6	9,918.5	6,849.9	6,849.9
	Нийт	129	1,494,677	1,534,793	86,537.4	98,411.3	65,718.4	65,718.4

2.8. Мөн НЭМГ-ын харьяа лавлагаа шатлалын ЭМБ-ууд нь ЭМДЕГ-аас зарласан цахим сонгон шалгаруулалтад оролцож шаардлага хангасан ОХБ-ээр ЭМДЕГ-тай гэрээ байгуулан, ЭМДҮЗ-өөс батлагдсан тусламж үйлчилгээний өртгийн жингээр тооцоолон нэхэмжлэл үүсгэж санхүүжилтийг авч байгаа бөгөөд зарим тохиолдолд ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан зарим ОХБ-ийн санхүүжилтийг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэлтэй байна. Тухайлбал:

2.9. НЭМГ-ын харьяа зарим лавлагаа шатлалын ЭМБ-ууд нь яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлж байгаа боловч улаан түвшний өвчтөнийг /маш хүнд/ хүлээн авч, төлбөрийг нэхэмжлэх эрх нь ЭМДЕГ-тай 2022 онд байгуулсан гэрээгээр үүсээгүй байна.

2.10. Энэ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.-д “Эмнэлгийн болон төрөх үеийн яаралтай тусламжийг тухайн иргэнд ойр байгаа эрүүл мэндийн байгууллага үзүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэхэд хүндрэлийг бий болгож байна.

2.11. Дээрх асуудлын хүрээнд ЭМБ нь улаан түвшний өвчтөнийг /маш хүнд/ хүлээн авч тусламж, үйлчилгээ үзүүлсэн өртгийг ЭМДЕГ-тай байгуулсан гэрээнээс шалтгаалан бодитоор нэхэмжлэх боломжгүй бөгөөд эдгээр тусламж үйлчилгээний гэрээгээр олгогдсон өртгийн жин рүү бууруулж нэхэмжлэх, өвчтөний хүнд хөнгөний зэргийг худал мэдүүлэх, өвчтөн нас барсан тохиолдолд эмчид хариуцлагын асуудал үүсэх эрсдэлтэй байна.

2.12. Иймд дээрх асуудлыг судалж, өвчтөнийг зөв эрэмбэлж, бодитоор нэхэмжлэх боломжийг бий болгож, ЭМДЕГ-тай гэрээтэй НЭМГ-ын харьяа ЭМБ-ын эрүүл

мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.13. 2022 онд ЭМДЕГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан мэдээг НЭМГ-ын харьяа лавлагаа шатлалын ЭМБ болон ӨЭМТ-дэд бүрэн хүргүүлж, хасагдалтын шалтгааныг мэдэгдэлгүйгээр санхүүжилтийг хасаж байгаа нь гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байх эрсдэлийг бий болгож байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг ЭМДЕГ-аас заасан дүрэм, журмын дагуу хянаж байгаа ч гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна.

2.14. НЭМГ-ын харьяа лавлагаа шатлалын ЭМБ-дад нийт 2021 онд 160.7 тэрбум төгрөг, 2022 онд 231.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ЭМДС-аас олгожээ. Аудитын түүвэрт хамрагдсан НЭМГ-ын харьяа ЭМБ-ын орлого, зарлага болон цалингийн зардлыг авч үзэхэд ЭМБ-ын нийт орлого 2021 онд 61.8 тэрбум төгрөг, 2022 онд 104.7 тэрбум төгрөг буюу 42.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс эмнэлгийн ажилчдын цалин хөлс, урамшууллын зардалд 2021 онд 25.3 тэрбум төгрөг, 2022 онд 41.8 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 7. ЭМБ-ын 2021 оны орлого, зарлагын гүйцэтгэл

№	Байгууллага нэр	Нийт орлого	Үүнээс		Нийт зардал	/сая.төг/ Үүнээс цалин хөлс, урамшуулал
			ЭМДС-аас орсон орлого	Бусад орлого		
1	ХУДЭМТ	7,592.0	6,720.3	871.7	7,591.0	3,646.0
2	СХДЭМТ	9,629.7	8,611.7	1,018.1	10,126.2	5.6
3	БГДЭМТ	19,866.7	19,141.5	725.1	19,811.5	7,958.0
4	СБДЭМТ	6,121.9	5,130.6	991.3	6,108.0	3,649.0
5	БЗДЭМТ	8,936.4	8,412.8	523.6	8,934.2	5,035.7
6	СХНЭ	9,630.9	8,688.4	942.5	9,623.9	5,052.1
	Нийт	61,777.6	56,705.4	5,072.2	62,194.8	25,346.5

Хүснэгт 8. ЭМБ-ын 2022 оны орлого, зарлагын гүйцэтгэл

№	Байгууллага нэр	Нийт орлого	Үүнээс		Нийт зардал	/сая.төг/ Үүнээс цалин хөлс, урамшуулал
			ЭМДС-аас орсон орлого	Бусад орлого		
1	ХУДЭМТ	13,630.3	12,810.1	820.2	13,212.1	4,631.2
2	СХДЭМТ	18,615.0	17,964.5	650.5	17,581.5	7,571.3
3	БГДЭМТ	27,132.7	25,832.6	1,300.1	21,753.9	9,466.2
4	СБДЭМТ	7,593.7	6,764.7	829.0	6,796.5	4,382.8
5	БЗДЭМТ	15,745.2	14,753.0	976.5	14,135.1	6,511.9
6	СХНЭ	21,947.5	20,334.6	1,612.9	18,684.9	9,277.3
	Нийт	104,664.26	98,459.39	6,189.21	92,164.08	41,840.69


2.15. Дээрх ЭМБ-ууд батлагдсан төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд Нийслэл дэх Төрийн аудитын газраас хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд нийт 1.4 сая төгрөгийн дүнтэй 1 төлбөрийн акт тогтоож, алдаа дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх нийт 4 албан шаардлага, 18 зөвлөмжийг өгсөн байна.

2.16. Харин 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд нийт 2.3 сая төгрөгийн дүнтэй 1 төлбөрийн акт тогтоож, алдаа дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх нийт 5 албан шаардлага, 16 зөвлөмжийг өгсөн байна.

Хүний нөөцийн хувьд:

2.17. Нийслэлийн харьяа 130 ӨЭМТ, 4 НЭ, 9 ЭМТ, 4 ТЭМТ-ийн хувьд нийт 1879 эмч ажиллаж байгаагаас хүний их эмч 1708, уламжлалтын эмч 119, шүдний эмч 52 тус тус ажиллаж байна. Үүнээс:

График 1. Эмч нарын мэргэшсэн байдал



2.18. Нийслэлийн харьяа 4 НЭ нийт 325 эмч ажиллаж байгаагаас хүний их эмчээр 303, уламжлалт анагаах ухааны эмч 14 шүдний эмч 8 байна. Үүнээс ерөнхий мэргэжлээр мэргэшсэн 32, анатомын эмгэг судлал 1, арьс 1, гэмтэл 7, дотор 44, хөнгөвчлөх 2, дүрс оношилгоо 18, ерөнхий мэргэшил 1, мэдрэлийн 17, мэс заслын 27, мэдээгүйжүүлэх 12, настны 1, нүдний 3, сүрьеэ 1, сэтгэцийн 2, сэргээн засах 6, хавдрын 6, халдвартын 2, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын 1, хүүхдийн 42, нярайн 5, чих хамар хоолойн 6, эмнэлзүйн эмгэг судлал-6, эх барих эмэгтэйчүүдийн 8, эрчимт эмчилгээ 27, хүүхдийн 9, яаралтай тусламж 11, хүүхдийн 4, бусад 21, байгаагаас мэргэшсэн байдлыг авч харвал дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд мэргэшсэн эмчийн тоо хүртээмжтэй байна.

2.19. Харин Нийслэлийн 9 дүүргийн ЭМТ нь нийт 737 эмч ажиллаж байгаагаас хүний их эмчээр 661, уламжлалт анагаах ухааны эмч 33, шүдний 43 эмч байна. Үүнээс ерөнхий мэргэжлээр мэргэшсэн 21, анатомийн эмгэг судлал 2, арьс 7, гэмтэл 20, дотор 110, хөнгөвчлөх 5, дүрс оношилгоо-54, ерөнхий мэргэшил-1, мэдрэлийн 38, мэс заслын 35, хүүхдийн 3, мэдээгүйжүүлэх-12, хүүхдийн-2, настны 5, нүдний 13, сүрьеэ 29, сэтгэцийн-13, сэргээн засах 16, хавдрын 11, халдвартын 27, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын 20, хүүхдийн 58, нярайн 3, чих хамар хоолойн 19, эмнэлзүйн эмгэг судлал-29, эх барих эмэгтэйчүүдийн-66, эрчимт эмчилгээ 14, хүүхдийн 2, яаралтай тусламж 12, бусад 49, байгаагаас мэргэшсэн байдлаар үзэхэд дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд мэргэшсэн эмчийн тоо эмчийн тоо хүртээмжтэй байна.

2.20. Нийслэлийн харьяа ӨЭМТ-д нийт 796 эмч ажиллаж байгаагаас хүний их эмчээр 728 эмч байна. Үүнээс ерөнхий мэргэжлээр мэргэшсэн 321, уламжлалт анагаах ухааны 68, анатомийн эмгэг судлал 1, арьс 1, гэмтэл 1, дотор 5, дүрс оношилгоо 4, ерөнхий мэргэшил 4, мэдрэлийн 2, мэс заслын 1, өрхийн эмч 367, сэргээн засах 2, халдвартын 1, хүүхдийн 14, эх барих эмэгтэйчүүдийн 4, эмч байгаагаас мэргэшсэн байдлаар үзэхэд ӨЭМТ нь хүүхэд болон эх барих эмэгтэйчүүдээр мэргэшсэн эмчийн тоо бага, мэргэшсэн эмч байхгүй байна. Тухайлбал:

- Шэжиддүг өрхийн эрүүл мэндийн төв
- Насан-урт өрхийн эрүүл мэндийн төв хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн мэргэшсэн эмчгүй байна.

Хүснэгт 9. ЭМБ-ын эмч нарын мэргэшлийн төрөл

Эрүүл мэндийн байгууллагууд	мэргэшлийн төрлөөр																																							
	Бүгд	Хүний их эмч -Бүгд	Ерөнхий мэргэшлийн	Анатомийн эмгэг судлал	Арьсны	Гэмтлийн	Дотрын	Хөнгөрчлөгийн	Дүрс оношилгооны	Ерөнхий мэргэшлийн	Зоонозын өвчний	Мэдээллийн	Мэс заслын	Хүүхдийн	Мэдээгүйчүүдэг	Хүүхдийн	Настны	Нүдний	Өрхийн эмч	Сүрьеэгийн	Сэтгэцийн	Сэргээж засахын	Хавдрын	Харшлын	Халдваргүйн	БЭДХ/ХДХБ/ДОХ-ийн	Хүүхдийн	Нарайн перинаталь	Цие хамар хоолойн	Эмнэлгийн эмгэг судлал (лаборатори)	Эх барих эмэгтэйнүүдийн	Эрчимт эмчилгээ	Хүүхдийн	Яаралтай тусламжийн	Хүүхдийн	Бусад	Уламжлалт анагаахын	Шүүний		
Өрхийн эрүүл мэндийн төв	796	729	321	1	1	1	5	0	4	4	0	2	1	0	0	0	0	0	367	0	0	2	0	0	1	0	14	0	0	0	4	0	0	0	0	0	0	0	68	0
Тосгоны эрүүл мэндийн төв	21	16	11	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	0	0	0	0	0	1	4	1	
Дүүргийн нэгдсэн эмгэг	325	303	32	1	1	7	44	2	18	1	0	17	27	0	12	0	1	3	0	1	2	6	6	1	2	1	42	5	6	6	8	27	9	11	4	21	14	8		
Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, НЭМҮТ	737	661	21	2	7	20	110	5	54	1	0	38	35	3	12	2	5	13	0	28	13	16	11	0	27	20	58	3	19	26	66	14	2	12	0	49	33	43		
Нийт	1879	1708	365	4	9	28	160	7	76	6	0	57	63	3	25	3	6	16	367	30	15	24	17	1	30	21	114	8	25	35	80	41	11	23	4	71	119	52		

Хүснэгт 10. Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын батлагдсан орон тоо

№	Байгууллагын нэр	Батлагдсан орон тоо	Ажилласан орон тоо	2022 он
1	ХУДЭМТ	224	193	
2	СХДЭМТ	491	363	
3	БГДЭМТ	396	321	
4	СБДЭМТ	256	153	
5	БЗДЭМТ	275	337	
6	ХУДНЭ	247	238	
7	СХНЭ	408	450	

2.21. НЭМГ-аас батлагдсан орон тоо ЭМБ-удын ажилласан орон тоог авч үзэхэд зарим ЭМБ-ууд нь батлагдсан орон тоогоор ажиллаагүй байна.

НЭМГ-ын харьяа дүүргүүдийн ӨЭМТ-дэд мэргэшсэн эмч нар дутагдалтай байна.

2.22. ЭМДЕГ-ын даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/12 дугаар, “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/20, “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” А/103 дугаар тушаалуудын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах зарим тусламж, үйлчилгээ үзүүлэх нийслэлийн өрх, тосгоны эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ЭМДЕГ зохион байгуулж, сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагуудын нэрс, тусламж, үйлчилгээний төрлийг ЭМДЕГ-ын даргын 2021 оны “Сонгон шалгаруулалтад тэнцсэн өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн жагсаалтыг батлах тухай” А/32 дугаар тушаалаар 02 дугаар сарын 26, А/109 дугаар тушаалаар 07 дугаар сарын 06-нд тус тус баталгаажуулжээ.

2.23. 2022 онд Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх даатгалын байгууллагатай гэрээтэй болон шинээр гэрээ байгуулах өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын дунд цахим сонгон шалгаруулалтын нэг, хоёрдугаар үе шатанд тэнцсэн эрүүл мэндийн байгууллагуудтай 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даатгалын гэрээ байгуулсан байна.

НЭМГ-ын харьяа ЭМБ болон ӨЭМТ-ийг ЭМДЕГ-аас сонгон шалгаруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулсан байна.

2.24. НЭМГ-ын харьяа нийт 21 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-г ЭМДЕГ-тай байгуулсан байна.

Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021-2022 онд олгосон санхүүжилт /НЭМГ-ын харьяа ЭМБ/

№	НЭМГ-ын харьяа ЭМБ	Олгосон санхүүжилт	
		2021.12.31	2022.12.31
	А	1	2
1	Баянгол ЭМТ	19,332.9	25,832.6
2	Чингэлтэй ЭМТ	10,465.2	14,571.1
3	Сонгинохайрхан ЭМТ	9,839.8	17,964.5
4	Хан-Уул ЭМТ	7,449.0	12,810.1
5	Сүхбаатар нэгдсэн эмнэлэг	14,703.0	18,662.3
6	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	9,388.4	20,303.8
7	Хан-Уул нэгдсэн эмнэлэг	7,532.7	11,966.3
8	Сүхбаатар ЭМТ	5,735.6	5,964.2
9	Баянзүрх ЭМТ	8,723.6	14,753.0
10	Налайх ЭМТ	8,722.6	12,885.0
11	Багануур ЭМТ	11,599.9	15,619.0
12	Энэрэл	2,766.2	2,617.3
13	Энэрэл эмнэлэг /Голд медикал/	-	103.8
14	Өргөө амаржих газар	12,131.5	13,835.4
15	Хүрээ амаржих газар	4,160.5	5,165.3
16	Нийслэлийн амгалан амаржих газар	9,696.5	11,382.8
17	УАУхааны элэг судлалын клиник төв	5,697.2	5,827.4
18	Нийслэлийн ШЭНЭСТ	584.3	1,064.6
19	Түргэн тусламжийн төв	10,882.7	17,456.9
20	Наркологийн эмнэлэг	903.8	1,677.1
21	Багахангай ЭМТ	350.3	639.5
	Нийт	160,665.6	231,102.0

2.25. ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтын үр дүнгээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээг 3 жилийн хугацаатай байгуулж, хавсралтыг жил бүр шинэчлэн батлахаар байна.

2.26. Мөн гэрээг байгуулахдаа ЭМДҮЗ-ийн 2022 оны 13 дугаар тогтоол “Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар шинэчлэн батлах тухай” мөрдлөг болгох бөгөөд гэрээнд дараах голлох заалтуудыг оруулсан байна.

Гэрээнд оролцогч талуудын эрх, үүрэгт тусгагдсан гол заалтууд:

- 2.1.7.3. Гэрээний 2.4.1-т заасан заасан хугацаанаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцроосон нэхэмжлэл;
- 2.1.7.4. тусгай зөвшөөрөлд заасан хаяг, байршлаас өөр хаяг байршилд үйлчилгээ үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэл;
- 2.1.7.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн Тусгай зөвшөөрөл эсхүл Магадлан итгэмжлэлийн хугацаа нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр сунгагдахдаа уг хугацаа дуусгавар болсон өдрөөс нөхөж сунгагдсан тохиолдолд дээрх хугацаан дахь тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэл.
- 2.4.2. төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглавартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх.

2.27. Аудитын түүвэрт хамрагдсан НЭМГ-ын харьяа лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг байгуулахдаа ЭМДҮЗ-ийн 2022 оны 13-р тогтоолын 3 дугаар хавсралтыг батлаагүй нь ЭМБ-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр бодитой дүгнэх боломжгүй байдалд бий болсон байна.

2.28. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний 5.1⁹-д заасны дагуу дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор дүгнэж, хавсралтыг шинэчлэн

⁹ 5.1. Энэхүү гэрээг эрх бүхий этгээдээс баталсан гэрээ дүгнэх аргачлал, журмын дагуу дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор дүгнэнэ.

гаргаагүй байгаа нь иргэдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрэн авахад хүндрэл үүсгэж байна.

2.29. Мөн гэрээний 1 дүгээр хавсралтад заасан ЭМДЕГ-тай гэрээгээр тохирсон тоо нь тухайн ЭМБ-ын иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хязгаарлаж байгаа нь эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоотой нийцээгүй байна.

2.30. ЭМДЕГ нь өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг ЭМДҮЗ-ын 04 дүгээр тогтоолын 1.2, 1.3 -д заасан тусламж, үйлчилгээний хүрээнд гэрээ байгуулдаг байна. Үүнд:

ЭМДҮЗ 04 тогтоол /1.2. заалт/

- Түргэн тусламж, үйлчилгээ
 - Яаралтай тусламж, үйлчилгээ
 - Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ
- ЭМДҮЗ 04 тогтоол /1.3. заалт/
- Зарим сэргээн засах үйлчилгээ
 - Оношилгоо, шинжилгээ
 - Өдрийн эмчилгээ
 - Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ

2.31. Дээрх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлөөр нийслэлд нийт 132 өрх, тосгоны эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Зарим сэргээн засах үйлчилгээ – 125 ЭМТ
- Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ – 130 ЭМТ
- Өдрийн эмчилгээ – 132 ЭМТ
- Оношилгоо, шинжилгээ – 112 ЭМТ

2.32. ЭМТ-үүдтэй байгуулсан 2021 оны даатгалын гэрээг ЭМДЕГ-ын даргын 2018 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Даатгалын гэрээ дүгнэх” журмын дагуу үнэлэх бөгөөд үнэлгээний аргачлал нь 100 онооны системтэй, 2 төрлийн буюу тийм бол 5, 10 үгүй бол 0 гэсэн үнэлгээ хийх аргачлалтай бөгөөд нийт 15 шалгуур үзүүлэлттэй байна.

2.33. ЭМДЕГ “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс зарим эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ дүгнэх ажлын хэсэг байгуулах, дүгнэх аргачлалыг батлуулах тухай” даргын 2022.01.11-ний өдрийн А/03 дугаар тушаалаар 2021 онд гэрээ байгуулсан өрх сум тосгоны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулсан байна.

2.34. 2022 онд дээрх тушаалын дагуу өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг ЭМДЕГ-аас ковид цар тахлын нөхцөл байдлын улмаас цахимаар үнэлсэн гэсэн тайлбарыг өгсөн боловч нотлох баримт болох 2021 оны даатгалын гэрээг дүгнэх үнэлгээний хуудсыг ЭМДЕГ-аас аудитын хугацаанд гаргаж өгөөгүй бөгөөд гүйцэтгэлийг бодитой дүгнэсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

2.35. “Даатгалын гэрээ дүгнэх журам”-ын 3.1.1-д “Даатгалын гэрээ дүгнэсэн үнэлгээний нийлбэр нь 81-100 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээг үргэлжлүүлж, мөн шинэчлэн байгуулж болно” гэж заасны дагуу ЭМТ-үүдтэй 2022 онд гэрээг үргэлжлүүлэн байгуулжээ.

НЭМГ-ын харьяа ЭМБ-ын даатгалын гэрээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэх боломжгүй байна.

2.36. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй НЭМГ-ын харьяа болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад иргэдэд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд суурилан санхүүжилтийг олгож эхэлснээр нийт 2020 онд 175.0 тэрбум, 2021 онд 306.7 тэрбум, 2022 онд 433.3 тэрбум төгрөг буюу 2020 онтой харьцуулахад 258.2 тэрбум төгрөгөөр буюу 2.5 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020, 2021 он, 2022 оны гүйцэтгэл /сая.төг/

№	Төрийн болон хувийн ЭМБ	ЭМДЕГ-аас олгосон санхүүжилт				
		2020.12.31	2021.12.31	Өссөн дүн	2022.12.31	Өссөн дүн
1	НЭМГ-ын харьяа ЭМБ	114,595.2	160,665.6	46,070.4	231,102.0	70,436.3
2	Хувийн ЭМБ	60,456.2	146,030.0	85,573.7	202,181.2	56,151.3
	Нийт	175,051.4	306,695.6	131,644.1	433,283.2	126,587.6

2.37. Харин зарим төрлийн тусламж үйлчилгээний хувьд нийслэл, дүүргийн харьяа ЭМБ-дад ачаалал буурахгүй байгаа бөгөөд Улаанбаатар хотын төвлөрөл болон агаар орчны бохирдолтой холбоотойгоор өвлийн улиралд хүүхдийн ханиад томууны өвчлөл эрс нэмэгддэг байна. Тухайлбал, БГДЭМТ-ийн хүүхдийн салбар эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх өвлийн 4 сарын мэдээллээс дурдахад дараах байдалтай байна.

Хүснэгт 13. БГДЭМТ-өөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо, мэдээ

Он сар өдөр	Хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо	Эмнэлгээс гарсан хүүхдийн тоо
2022.10.01-10.31	616	616
2022.11.01-11.31	524	517
2022.12.01-12.31	672	623
2023.01.01-01.31	911	870
Нийт	2723	2631

2.38. Мөн НЭМГ-ын харьяа ЭМБ-ын хүүхдийн эндэгдлийн тоо мэдээг 2021-2022 онтой харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 14. 2021-2022 оны Хүүхдийн эндэгдлийн тоо НЭМГ-ын харьяа ЭМБ-аар

№	ЭМБ-ын нэр	Нялхсын эндэгдэл		Өсөлт / бууралт	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		Өсөлт / бууралт
		2021	2022		2021	2022	
1	БГДЭМТ	1	6	5	2	2	0
2	БЗДЭМТ	4	3	-1	6	2	-4
3	СХДЭМТ	4	3	-1	1	2	1
4	СБДЭМТ	5	1	-4	2	0	-2
5	ХУДЭМТ	3	2	-1	1	1	0
6	ЧДЭМТ	1	1	0	0	1	1
7	НДЭМТ	8	6	-2	1	2	1
8	БНДЭМТ	4	7	3	1	3	2
9	БХДЭМТ	0	0	0	0	0	0
10	БЗНЭ	4	6	2	1	1	0
11	СХНЭ	5	1	-4	0	2	2
12	СБНЭ	1	1	0	0	0	0
13	ХУНЭ	0	1	1	0	2	2
	Нийт	40	38	-2	15	18	3

2.39. Мөн НЭМГ-ын харьяа ЭМБ-ууд нь ЭМДЕГ-аас яаралтай түргэн тусламжийн улаан эрэмбээр нэхэмжлэл илгээх боломжгүй байгаатай холбогдуулан нийслэлийн хүн амд үзүүлэх яаралтай түргэн тусламжийн ачааллыг бууруулах зорилгоор ЭМЯ-аас хувийн хэвшлийн 5 эмнэлэгт хуваарилалт хийсэн байна.

2.40. Иймд НЭМГ-ын харьяа хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэгч ЭМБ-ын хүүхдийн тасгийн хүний нөөц, хүчин чадлыг нэмэгдүүлж, ЭМДЕГ-тай хүүхдийн өвчлөлтэй холбоотой ОХБ-ийн тоог шаардлагатай байгаа хэмжээнд нэмэгдүүлж гэрээлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

2.41. ЭМДЕГ-аас хувийн хэвшлийн хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг ЭМБ-тай бусад төрлийн тусламж үйлчилгээтэй хосолсон байдлаар гэрээлэх нөхцөл бололцоог судлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ЭМБ-ын үр дүнд суурилсан тогтолцоогоор санхүүжилт олгож байна.

2.42. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт цахим системийг нэвтрүүлсэн хэдий ч иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, өргөдөл гомдлыг шийдвэрлэж хариу арга хэмжээ НЭМГ-ын хувьд хангалтгүй байна.

2.43. НЗД-ын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/932 дугаар захирамжаар¹⁰ батлагдсан “НЭМГ-ын дүрэм”-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг зохион байгуулах, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх талаар тодорхой тусгаж өгсөн.

2.44. НЭМГ-ын 2021-2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд харьяа нутаг дэвсгэрийнхээ хүрээнд иргэдэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийх ажлыг тусган эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллажээ. Тухайлбал: НЗД-ын 2021 оны А/887 дугаар захирамжийн дагуу¹¹ НЭМГ, НЦУГ, ННХГ-тай хамтран 239 иргэнийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулсан байна.

2.45. НЭМГ нь “Нийслэлийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г батлуулаагүйгээс дээрх чиглэлээр харьяа байгууллагууддаа нэгдсэн чиглэл өгөх боломжгүй, арга зүйгээр хангах нөхцөл бүрдээгүй байна.

2.46. Зарим ЭМБ-ын хувьд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдэд тусламж үзүүлэх ажлыг тусган хэрэгжүүлж ажилласан байна. Жишээ нь :

2.47. БЗДЭМТ нь 2022 онд холбогдох хууль, тогтоомжуудыг¹² үндэслэн “Нийслэлийн орон гэргүй, тэнэмэл иргэд”-ийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах “ИЛРҮҮЛЭЛТ-2022” үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 42 орон гэргүй, бүртгэлгүй иргэн хамрагдаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан. БЗДЭМТ-тэй Тэрэм уул ТББ, Дөлгөөн минж ТББ, Шинэ амьдрал ТББ-ууд хамтран ажиллажээ.

2.48. ЭМС болон НЗД-тай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд нийслэл хотод түр оршин сууж байгаа болон явуулын иргэдэд тусламж үзүүлэх мөн алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг тусгасан хэдий ч шалгуур үзүүлэлтийг тоон үзүүлэлтээр тодорхойлоогүй учраас үр дүнг хэмжих боломжгүй байна.

Хүснэгт 15. Дүүргүүдийн дундаж хүн ам

№ Байршил Дундаж хүн ам /2021 он/ Дундаж хүн ам /2022 он/

¹⁰ Нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрэм”-ийн 3.2-д эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах

¹¹ “Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн талаар авах арга хэмжээний тухай”

¹² Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүний эрхийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 1 зүйлийн 1.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21, 8.1.24 болон Нийслэлийн засаг даргын 2022 оны А/148 тушаалын дагуу

1	Баянгол	228398	233951
2	Баянзүрх	364606	375786
3	Сонгинохайрхан	332952	338622
4	Сүхбаатар	145007	144579
5	Хан Уул	190589	202762
6	Чингэлтэй	151171	150876
7	Налайх	38203	38810
8	Багануур	28908	29388
9	Багахангай	4313	4461
10	Дүүргийн дүн	1484146	1519196

Эх сурвалж : НЭМГ-ын 2022 оны статистик эмхэтгэл

2.49. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь хүн бүрд аливаа ялгаваргүйгээр, тэгш, хүртээмжтэй байх ёстой хэдий ч түүвэрт хамрагдсан ЭМБ-ын 50 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангах ээлтэй, таатай орчин бүрдүүлээгүй байна.

2.50. ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагааны стандартад¹³ гэж заасан боловч үнэлгээнд хамрагдсан ӨЭМТ-өөр үйлчлүүлэгчдийн 40 хувь нь 15 минут, 30 хувь нь 30 хүртэл минут, 30 хувь нь 1 цаг хүртэл хугацааг өрхийн эрүүл мэндийн төвд очиход зарцуулдаг гэжээ. Жишээ нь:

2.51. БХД-ийн хувьд 5,000 орчим байнгын оршин суугчтай, 2 хороотой алслагдсан дүүрэг бөгөөд өрхийн эрүүл мэндийн төвгүй, харин дүүргийн эрүүл мэндийн төвийн салбар ажиллаж байна. Тус дүүрэгт нийтийн тээврийн үйлчилгээ байхгүй, иргэд 8 км-ийн цаана байрлах дүүргийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхэд хүндрэлтэй байдаг.

ЭМБ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлоогүй ч эрүүл мэндийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

2.52. ЭМС-ын “Эрүүл мэндийн салбарт 2021 оноос хэрэгжүүлэх шинэчлэлийн бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны хүрээнд цахим, технологийн бэлтгэлийг эрчимжүүлэх тухай” албан даалгаврын хүрээнд ЭМБ-дад мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдлыг хангаж, даатгуулагчдад шуурхай, чирэгдэлгүй, чанартай, тусламж, үйлчилгээ үзүүлэхийг үүрэг болгосон.

2.53. Мөн тус албан даалгаварт НЭМГ-ыг “харьяа эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж, удирдлага чиглэл өгч, мэргэжил арга зүйгээр хангах мөн шаардлага хангасан программ хангамж нэвтрүүлэх, программ хангамжтай бол шаардлагатай модулийн ашиглалтыг бий болгох, үйл ажиллагааны тасралтгүй байдалд тогтмол хяналт тавих ажилтныг товлож үйл ажиллагаанд хяналт тавих” тухай заасан байна.

2.54. Үүний хүрээнд НЭМГ харьяа 26 ЭМБ, 159 ӨЭМТ-ийн мэдээллийн технологийн үйл ажиллагаа, цахим системийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

НЭМГ нь мэдээллийн технологийг хөгжүүлж, эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт дэвшүүлэн 2022 онд БГД, БЗД, СХД-ийн ЭМТ-дэд “Цахим шилжилт” төслийг хэрэгжүүлэхээр 4 бүлэг 24 үйл ажиллагааг төлөвлөн төсөв санхүүжилтийг 20 тэрбум байхаар тооцоолж НИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай”

¹³ үйлчлүүлэгч явганаар болон унаагаар 15-30 минутын дотор очих боломжтой зайд өрхийн эрүүл мэндийн төв байрлана

11/31 дүгээр тогтоолоор дэмжигдсэн боловч улс, нийслэл, орон нутгийн төсөвт тусгагдаагүй гэсэн шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон байна.

2.55. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 48 лавлагаа шатлалын ЭМБ www.e-health.mn системийг, 547 анхан шатны ЭМБ www.e-hospital.mn системийг, нийт 700 ЭМБ www.health.gov.mn цахим системийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 109 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд ӨЭМТ-дэд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд www.e-hospital.mn цахим системийг ашиглаж байна.

2.56. Зарим дүүргийн эрүүл мэндийн төвүүдтэй хөгжүүлэгч компани болох “Метекс плас” ХХК нь нэмэлтээр системийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Тухайлбал: 2021 оны 1 дүгээр сард ХУД-ийн ЭМТ “Метекс плас” ХХК-тай системийн үйлчилгээ /PACS сервер суулгах, рентген, эхо, лабораторийн төхөөрөмж суулгах/ үзүүлэх гэрээ байгуулан, 1 төхөөрөмж тус бүр дээр 350,000 төгрөгийн төлбөр авч, 1 сарын ажлын хөлс 1,500,000 төгрөгийн төлбөр авч хагас жилийн хугацаанд ажилласан байна.

2.57. Нийслэлийн харьяа ӨЭМТ-үүд бодит цагийн горимоор үйлчлүүлэгчийн үзлэгийн талаарх мэдээллийг ЭМДЕГ-ын цахим систем болох health.gov.mn-ийг ашиглан ЭМДЕГ-т илгээж байгаа бол хөнгөлөлттэй эмийн жор бичихдээ e-hospital.mn цахим системийг ашиглаж байгаа.

2.58. ЭМС-ын 2020 оны А/495 дугаар тушаалаар баталсан “Цахимаар эмийн жор бичих, олгох заавар”-ын 3.3-т “Эмч цахим жорыг өөрийн болон иргэний хурууны хээгээр баталгаажуулна.”, ЭМДЕГ-ын даргын 2020 оны А/115 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.3.1-д¹⁴ гэсэн заалтууд мөрдөгдөж байна.

2.59. Анхан шатны ЭМБ-ууд e-hospital цахим систем дээр хөнгөлөлттэй эмийн цахим жорыг бичиж байгаа хэдий ч эмчийн болон иргэний хурууны хээний баталгаажилт хийгдэхгүй байна.

2.60. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ЭМБ-дад ашиглагдаж байгаа программ хангамжуудыг иргэдийг мэдээллээр хангах зорилгоор e-mongolia системтэй холбох ажил хийгдэж 2022 оны 10 дугаар сарын байдлаар эмнэлгийн магадалгааг 64573 иргэн, цаг захиалгын үйлчилгээг 62025 иргэн, цаг цуцлах үйлчилгээг 12818 иргэн, шинжилгээний хариу авах үйлчилгээг 15707 иргэн тус тус цахимаар авсан байна.

2.61. Нийслэлийн харьяа ЭМБ-ууд үйл ажиллагаандаа 26 цахим системийг ашиглаж байгаа бөгөөд НЭМГ хяналт тавих боломжгүй, хөгжүүлэгчид компаниудад шаардлага тавих эрхгүй байна. Эмнэлгийн албан хаагчид олон систем ашигласнаар цаг хугацаа алдаж байгаа нь ачаалал үүсгэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Цахим системийн хөгжүүлэлт хангалтгүй, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах талаар төлөвлөсөн ажил байхгүй, мөн хурууны хээний баталгаажилт хийгдэхгүй байгаа нь иргэдийн хувийн мэдээлэлд эрсдэл үүсгэж байна.

¹⁴ “Эрүүл мэндийн байгууллага, эмч нь үнийн хөнгөлөлт үзүүлэх цахим жорыг даатгуулагчдад мэргэжлийн дагуу үзлэг хийж, даатгуулагчийн иргэний үнэмлэх, даатгуулагчийн хурууны хээний баталгаажуулалт дээр үндэслэн бичих бөгөөд жор бичсэн эмч мөн хурууны хээний баталгаажуулалт давхар хийж, цахим жор хүчинтэй болно”

2.62. Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.8, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, ЭМС-ын 2022 оны А/50 дугаар тушаал, НЭМГ-ын даргын 2022 оны А/105 дугаар тушаалын дагуу нийслэлийн харьяа ЭМБ иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ.

2.63. НЭМГ нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд иргэдийн өргөдөл, гомдол гаргах эрхийг хангах зорилгоор гомдол, санал, хүсэлтийг бичгээр, утсаар, цахимаар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв”-өөр болон биечлэн хүлээн авч шийдвэрлэж байна.

2.64. Иргэдээс ЭМБ-ын үйл ажиллагаатай холбоотой 2021 онд нийтдээ 8941, 2022 онд 4042 өргөдөл, гомдол ирүүлсэн байна. Үүнээс 2021 онд 8676 өргөдлийг шийдвэрлэсэн бол 2022 онд 3931 өргөдөл гомдлыг шийдвэрлэжээ.

2.65. НЭМГ-т ирсэн нийт өргөдлийн 23.9 хувь нь Коронавируст халдвартай холбоотой хүсэлт, санал, мэдээлэл авах тухай асуудал зонхилж байсан бол үлдсэн санал, гомдлын 20.7 хувь нь эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой, 4.4 хувь нь эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой, 8.7 хувь нь эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой, 4.1 хувь ажилтнуудын нийгмийн асуудалтай холбоотой, 19.7 хувь нь талархлаа илэрхийлсэн, 18.2 хувь нь бусад асуудлаар хандсан байна.

2.66. Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой гомдлыг ЭМБ-ууд холбогдох, тасаг, албанд, ӨЭМТ-ийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудад хүлээлгэн өгч, үйлчлүүлэгчтэй нь холбож өгдөг бөгөөд гомдол хэрхэн шийдвэрлэгддэг, шийдвэрлэсэн байдал нь мөн тодорхойгүй, гомдол гаргагчид хариу мэдэгддэггүй, зөрчлийг дахин гаргахгүй байх талаар авч байгаа хариу арга хэмжээ, үр дүн тодорхойгүй байна.

2.67. ХЭҮК-оос 2022 онд Нийслэлийн харьяа ЭМБ-дад иргэдээс өргөдөл, гомдолд хүлээн авч шийдвэрлэж байгаа байдалд үнэлгээ хийсэн ба тайланд дүүргийн нэгдсэн эмнэлэгт үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргасан хүмүүсийн 6.2 хувь нь хариу аваагүй, 1.2 хувь нь шийдвэрлээгүй орхисон гэж үзсэн бол 81.5 хувь нь асуудлаа шийдвэрлүүлж чадсан гэсэн байна. Харин амбулаториор үйлчлүүлэгчдийн хувьд дээрх үзүүлэлт харьцангуй муу буюу 48 хувь нь хариу аваагүй, 18 хувь нь шийдвэрлүүлж чадаагүй гэж хариулснаас үзэхэд амбулаторийн үзлэгт хамрагдаж буй үйлчлүүлэгчтэй эргэн холбогдож гомдлын хариу өгдөггүй байна.

2.68. НЭМГ-ын даргын баталсан “Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам”-ын 3.1.2.4-д “Өргөдөл, гомдлын мэдээлэлд 7 хоног бүр дүн шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр ханган ажиллана” гэж заасан боловч энэ заалтын хэрэгжилт хангалтгүй, тайлан мэдээ гаргаагүй байна. Мөн тус журмын 4 дүгээр зүйлд өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх багийн үйл ажиллагааг зохицуулж, “орон тооны бус баг” байхаар заасан боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.69. НЭМГ 2022 оны 10 дугаар сард өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчийг томилж ажиллуулж эхэлжээ. НЗД-ын 2022 оны А/1538 дугаар захирамжийг үндэслэн иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажлын

хэсгийг томилон харьяа ЭМБ-ын өргөдөл, гомдлын шийдвэрлэлд хяналт тавьсан байна. Хяналт шалгалтын дүнд харьяа ЭМБ-ууд иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлыг өдөрт нь хүлээн аваагүй нийтлэг зөрчил илэрчээ. Тухайлбал:

Хүснэгт 16. ЭМБ-ууд иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлын тоо

№	ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ	ЗӨРЧЛИЙН ТОО
1	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	71
2	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	11
3	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	2
	НИЙТ	84

2.70. НЭМГ нь 2021 оны тухайд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, харин 2022 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн хуульд заасан мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх үүрэг хүлээсэн.

2.71. НЭМГ үйл ажиллагааныхаа онцлогт тааруулан мэдээллийг ил тод байршуулах, иргэдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд 2018 онд А/79 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан. Журмаар НЭМГ-ын цахим хуудасны мэдээллийн үндсэн чиглэл, мэдээлэл тавих журам, хариуцах албан тушаалтны чиг үүрэг, мэдээлэл байршуулах хуваарь, байршуулсан мэдээллийн бүртгэл зэргийг зохицуулахаар заасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

2.72. Харьяа ЭМБ-ууд дотооддоо мэдээллийн ил тод байдлын журам боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байгаа хэдий ч 2021 онд батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчлэлтэй нийцүүлээгүй байна.

2.73. НЗД-ын 2016 оны А/932 дугаар захирамжаар батлагдсан НЭМГ-ын дүрмийн 2.5.12-д “харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэсэн тусгасан хэдий ч харьяа байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт хийдэггүй, хариуцсан албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт дээр хяналт тавих чиг үүргийг тусгаагүй байна. Мэдээллийн ил тод байдлын журамдаа өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр олон нийтэд ил тод мэдээлэх талаар тусгасан хэдий ч энэ ажил хэрэгжээгүй байна.

Иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, өргөдөл гомдлыг шийдвэрлэх хариу арга хэмжээ НЭМГ-ын хувьд хангалтгүй байна.

2.74. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд тавих хяналт сул, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомж, журамд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх байдал ӨЭМТ-ийн хувьд хязгаарлагдмал, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус байна.

2.75. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11/31 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хүлээн авч, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна. Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд НЭМГ хариуцах 47 арга хэмжээ тусгагдаж, тэдгээрийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 67.7 хувьтай буюу Эрчимжүүлэх шаардлагатай үнэлэгджээ.

2.76. Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолын 4.1¹⁵-д ЭМБ-ууд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж эсвэл ажилтантай байна гэж заасан. Түүвэрт орсон Нийслэлийн харьяа СБД-ийн ЭМТ, БГД-ийн ЭМТ, ХУД-ийн ЭМТ, СХД-ийн ЭМТ-үүд нь 2021-2022 онуудад хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтантай байхаар бүтцээр заасан боловч чанарын албаны дарга нь хяналт-шинжилгээ үнэлгээний ажлыг хавсран хийсэн байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.2-т заасан “Дотоод хяналт шалгалтын нэгж ажилтан нь тухайн аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.77. НЗД-ын 2022 оны Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2022 оны ажил дүгнэх тухай А/1592 дугаар захирамжийн дагуу хийсэн хяналт шалгалтаар НЭМГ-ын үйл ажиллагааг “ажил сайжруулах шаардлагатай” гэж НЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний газар үнэлсэн байна. Үнэлгээнд үндэслэн 2023 оны үйл ажиллагаанд анхаарч ажиллах зөвлөмжийг НЗДТГ-аас НЭМГ-т 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүргүүлсэн. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гаргасан зөвлөмжөөс дурдвал :

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаар:

1.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт шалгуур үзүүлэлтийг тодорхой нарийвчилсан, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, хугацаатай төлөвлөх;

1.2 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хүлээн авах, танилцуулах карт хөтлөх, хяналт тавих;

1.3 Бодлогын баримт бичгийн арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа гол үр дүн тоо, чанараар илэрхийлж гаргах ба 2022 оны НЗД А/1106 захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийг нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6-д заасны дагуу байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан мэдээнд тавигдах шаардлагыг хангасан байх;

НЭМГ болон харьяа зарим ЭМБ-уудад хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан ажиллаагүй, чанарын дарга нар нь хавсран хийж гүйцэтгэсэн нь хангалтгүй байна.

2.78. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, хууль эрх зүйн өөрчлөлтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын дараах асуудлыг шийдвэрлэх зорилготой хийжээ. Үүнд:

Асуудал 1: Эмнэл зүйн удирдамжийн хэрэглээ хангалтгүй

Асуудал 2: Эмийн чанар муу

Асуудал 3: Санхүүжүүлэгч байгууллага чанарыг хянадаггүй зэрэг байна.

2.79. Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна. Үүнд:

- “14.8.7.даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэхэд баримтлах

¹⁵ Бүх шатны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна

шалгуур бүхий журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах;”

- “23.2.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.”
- “16.1.5.даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;”

2.80. Энэхүү хуулийн өөрчлөлтийг хийж эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлснээр гарах үр дүн дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг санхүүжилттэй нь уяснаар эмнэлгүүд олон улсын эмнэл зүйн удирдамж ашигладаг болно;
- Олон улсад хэрэглэдэг эмнэл зүйн удирдамж ашигласнаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар дээшилнэ;
- Хаана ч ижилхэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэнэ.

2.81. ЭМДЕГ-аас аудитын хугацаанд өгсөн мэдээгээр 2021-2022 онд НЭМГ-ын харьяа ЭМБ-дад нийт 391,663.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, нийт 8,058.1 сая төгрөгийн хасалтыг нэхэмжлэлийн хэлтсээс хийснээс 2021 онд 2,830.9 сая төгрөг, 2022 онд 5,227.2 сая төгрөг буюу хасагдалт 84.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 17. ЭМДЕГ-аас 2021-2022 онд олгосон санхүүжилт, хасагдалт /ЭМБ/

№	Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлэг нэр	Нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан дүн		Өсөлт, бууралт /хувь/	Олгосон санхүүжилт		Өсөлт, бууралт /хувь/
		2021	2022		2021	2022	
А	1	2	3	4	5	6	7
1	Багануур ЭМТ	166.6	258.9	55.4	11,599.9	15,619.0	34.6
2	Багахангай ЭМТ	123.7	23.2	(81.2)	350.3	639.5	82.6
3	Баянгол ЭМТ	46.9	1,554.6	3,216.6	19,332.9	25,832.6	33.6
4	Баянзүрх ЭМТ	192.9	77.5	(59.8)	8,723.6	14,753.0	69.1
5	Налайх ЭМТ	96.7	376.9	289.9	8,722.6	12,885.0	47.7
6	Наркологийн эмнэлэг	1.0	7.2	622.9	903.8	1,677.1	85.6
7	Нийслэлийн амгалан амаржих газар	346.7	220.7	(36.3)	9,696.5	11,382.8	17.4
8	Нийслэлийн ШЭНЭСТөв	7.7	14.8	91.0	584.3	1,064.6	82.2
9	Өргөө амаржих газар	74.7	178.2	138.6	12,131.5	13,835.4	14.0
10	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	154.4	732.3	374.2	9,388.4	20,303.8	116.3
11	Сонгинохайрхан ЭМТ	33.1	434.7	1,214.5	9,839.8	17,964.5	82.6
12	Сүхбаатар нэгдсэн эмнэлэг	108.3	394.9	264.7	14,703.0	18,662.3	26.9
13	Сүхбаатар ЭМТ	6.3	13.9	122.5	5,735.6	5,964.2	4.0
14	Түргэн тусламжийн төв	1,302.9	152.4	(88.3)	10,882.7	17,456.9	60.4
15	УАУхааны элэг судлалын клиник төв	-	10.0	-	5,697.2	5,827.4	2.3
16	Хан-Уул нэгдсэн эмнэлэг	15.7	226.1	1,342.9	7,532.7	11,966.3	58.9
17	Хан-Уул ЭМТ	117.3	134.7	14.8	7,449.0	12,810.1	72.0
18	Хүрээ амаржих газар	18.9	98.7	421.2	4,160.5	5,165.3	24.2
19	Чингэлтэй ЭМТ	15.4	249.7	1,523.0	10,465.2	14,571.1	39.2
20	Энэрэл	1.8	67.7	3,558.9	2,766.2	2,617.3	(5.4)
	Нийт	2,830.9	5,227.2	84.6	160,665.6	230,998.2	43.8

2.82. Дээрх хүснэгтээс харахад 2021-2022 онд НЭМГ-ын харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДЕГ-аас олгосон санхүүжилт 70,332.6 сая төгрөг буюу 43.8%-аар өссөн байна. Мөн 2021-2022 онд ЭМДЕГ-ын олон улсын эмнэл зүйн удирдамжийн дагуу боловсруулсан цахим болон цаасан суурьт нэхэмжлэлийн хяналтын хасагдалт 2,396.3 сая төгрөг буюу 84.6%-аар өссөн байна.

2.83. 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хасагдалтын хувь нь санхүүжилтийн өсөлтийн хувиас 1.9 дахин их байгаа нь чанаргүй тусламж үйлчилгээний тоо нэмэгдсэн, түүнд тавигдах хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааны үр нөлөө бага байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлд тавих хяналт сул байна.

2.84. НЭМГ-ын харьяа ЭМБ-ын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ЭМС-ын 2022 оны А/346 дугаар тушаал, НЭМГ-ын даргын 2022 оны А/256 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын хүрээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийжээ. Уг хяналт шинжилгээ, үнэлгээгээр дараах нийтлэг алдаа, дутагдал илэрсэн байна. Үүнд:

- Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үйл ажиллагааны бичмэл тайланг хавсаргаж ирүүлээгүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ нь зорилтот түвшинтэй уялдаагүй, шалгуур үзүүлэлт нь тодорхой бус;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн баталгаажуулалт, тайлан хангалтгүй;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хэрэгжилтийн тайланг хугацаанд нь ирүүлээгүй;
- Мэдээллийн ил тод байдал, тушаал шийдвэр оруулаагүй, дутуу болон зарим байгууллагын албан ёсны сайт нь ажиллагаагүй;
- Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг дутуу өгч хангалтгүй ажилласан;
- Албан хэрэг хөтлөлт стандартын бус, үг үсгийн алдаатай зэрэг болно.

2.85. Дээрх хяналт шинжилгээ, үнэлгээг НЭМГ-ын даргын 2023 оны “Харьяа Эрүүл мэндийн байгууллагуудад үр дүнгийн урамшуулал олгох тухай” А/02 дугаар тушаалаар баталгаажуулсан байна.

Хүснэгт 18. Нийслэлийн шүд, эрүү нүүрний төвийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үнэлгээний дүн

	Үзүүлэлт	Хувь	Жин	
Байгууллагын чиг үүргийн үнэлгээ	1. Байгууллагын жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	18.4	0.184	
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	13	0.13	
	3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт	26.4	0.264	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	4. Байгууллагын ил тод байдал	Үйл ажиллагааны ил тод	4.475	0.04475
		Хүний нөөцийн ил тод	4.65	0.0465
	5. Хэрэглэгчийн үнэлгээ	Шилэн данс хөтлөлт	3.9	0.039
		Ерөнхий үнэлгээ:	89.2 (B)	0.89165

2.86. НЭМГ-ын харьяа ЭМБ-ын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үнэлгээний нэгтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 19. Харьяа ЭМБ-ын 2022 оны үнэлгээ

№	ЭМБ-ын нэр	Ерөнхий үнэлгээ	Хувь	Жин
1	Багануур ЭМТ	А	92.8	0.93
2	Багахангай ЭМТ	В	84.0	0.84
3	Баянгол ЭМТ	А	90.5	0.91
4	Баянзүрх ЭМТ	В	87.7	0.88
5	Налайх ЭМТ	А	91.1	0.91
6	Наркологийн эмнэлэг	А	91.1	0.91
7	Нийслэлийн ШЭНЭСТөв	В	89.2	0.89
8	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	А	93.9	0.94
9	Сонгинохайрхан ЭМТ	В	87.8	0.88
10	Сэргээн засах клиник эмнэлэг	В	88.1	0.88
11	Сүхбаатар нэгдсэн эмнэлэг	А	92.3	0.92
12	Сүхбаатар ЭМТ	В	80.3	0.80
13	Түргэн тусламжийн төв	А	93.6	0.94
14	Хан-Уул нэгдсэн эмнэлэг	А	90.4	0.90
15	Хан-Уул ЭМТ	С	79.4	0.79
16	Чингэлтэй ЭМТ	С	79.5	0.79
17	Энэрэл	В	89.5	0.89
	Дундаж		88.3	0.88

2.87. Дээрх үнэлгээнээс харахад ХУД-ийн ЭМТ 79.4% болох хамгийн бага буюу С үнэлгээг авсан боловч ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн хяналтын хасагдалт 2021-2022 онд 14.8%-аар өссөн нь бусад НЭМГ-ын харьяа ЭМБ-тэй харьцуулахад бага байна. Энэ нь НЭМГ-ын харьяа ЭМБ-ийн үйл ажиллагааны үнэлгээг хийхдээ ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн хяналтын хасагдалт, үр дүнтэй уялдуулаагүй байгааг харуулж байна.

2.88. НЭМГ-ын харьяа ЭМБ болон ӨЭМТ-дэд ЭМДЕГ-тай байгуулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний 2.1.1¹⁶-д заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч тал буюу ЭМДЕГ-аас хяналт тавих чиг үүрэгтэй байна.

2.89. Харин НЭМГ-ын харьяа ЭМБ-дад НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг болох Нийслэлийн дотоод аудитын албанаас хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, хяналт шалгалтаар 2022 онд нийт 14 ЭМБ-д нийт 139 удаагийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгч, 219.6 сая төгрөгийн акт тавьсан байна.

Хүснэгт 20. Нийслэлийн дотоод аудитын албанаас 2022 онд аудит, хяналт шалгалтад хамрагдсан ЭМБ-ын дүн, мэдээ

№	ЭМБ-ын нэр	Өгсөн зөвлөмж, зөрчлийн дүн			Үүнээс		/мян.төг/
		Өгсөн зөвлөмжийн тоо	Мөнгөн дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж	
1	БНД ЭМТ	10	546,452.2	31,270.5	-	515,181.6	
2	ХУД НЭ	10	633,983.0	7,500.0	-	626,483.0	
3	НШЭНТ	10	234,635.7	6,000.0	-	228,635.7	
4	БЗД ЭМТ	8	2,678,000.8	14,453.3	-	2,663,547.5	
5	ЧД ЭМТ	8	807,286.9	-	-	807,286.9	
6	СБД ЭМТ	10	57,300.0	57,300.0	-	-	
7	Энэрэл	4	121,045.0	1,045.0	-	-	
8	Наркологи	5	168,044.2	-	-	-	
9	НД ЭМТ	11	1,604,359.7	6,530.5	-	1,597,829.2	
10	НТТТ	9	208,730.5	-	-	208,730.5	
11	ХУД ЭМТ	8	342,468.5	-	-	342,468.5	
12	СХД ЭМТ	23	765,171.7	85,576.7	-	679,594.6	
13	БГД ЭМТ	16	851,353.0	6,892.9	-	844,460.1	
14	СХД НЭ	7	820,272.9	3,049.6	-	817,223.3	
	Нийт	139	9,839,104.1	219,618.5	-	9,331,440.9	

2.90. Мөн НЭМГ-ын харьяа орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг дүүргийн засаг дарга шууд

¹⁶ 2.1.1. иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын дагуу чанарын болон төлбөрийн хяналт хийх;

батламжилна гэж Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.30¹⁷-д заасан байна.

2.91. Дээрх заалтын дагуу СХД-ийн нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн өмчлөгчийг төлөөлсөн гишүүнийг Засаг даргын 2022 оны А/545 дугаар тушаалаар баталсан байна. Мөн 2022 онд СХД-ийн нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, эмнэлгийн дарга нар үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан бөгөөд уг гэрээнд ТУЗ-ийн хяналт тавих чиг үүрэгтэй холбоотой эрх, үүргийн нарийвчлан тусгаагүй байна.

2.92. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4¹⁸-т заасны дагуу ЭМС-ийн 2022 оны “Журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай” А/104 дүгээр тушаалаар ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр хяналт тавих журмыг баталсан байна.

2.93. Аудитын түүвэрт хамрагдсан ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд тавьсан хяналтын үнэлгээгээр бүрэн хангалттай, хангалттай гэж дүгнэгдсэн бөгөөд хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийг дүүргүүдийн эрүүл мэндийн төвүүдээс гаргаж ажилласан бөгөөд 2022 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг НЗД-ын 2022 оны А/1647 дугаар захирамжаар баталжээ.

Хүснэгт 21. Түүвэрт хамрагдсан ӨЭМТ-ийн 2022 оны гэрээний биелэлт

№	ӨЭМТ-ийн нэр	Дүүрэг	Хороо	Гэрээний биелэлт				
				Эхний хагас	Сүүлийн хагас	Жилийн эцэс	Дүн	Үнэлгээ
А	1	2	3	4	5	6	7	8
1	Угтахуй ӨЭМТ	Баянгол	4, 25	85.1	86.8	85.9	В	Хангалттай
2	Ачлахуй	Баянзүрх	8	86	92	89	В	Хангалттай
3	Евро эм	Баянзүрх	14	91.6	94.7	93.1	А	Бүрэн хангалттай
4	Насан Урт	Баянзүрх	16	91.3	92	91.6	А	Бүрэн хангалттай
5	Тэгш дүүрэн хүслэн	Баянзүрх	26	88.6	91.1	89.9	В	Хангалттай
6	Хасагт Эрдэнэ	Баянзүрх	5	92.6	94.8	93.7	А	Бүрэн хангалттай
7	Гурван жаргал хайрхан	Сонгинохайрхан	18, 38	93.9	83.3	88.6	В	Хангалттай
8	Дотны туслагч	Сүхбаатар	11	92	90.5	91.2	А	Бүрэн хангалттай
9	Амгалан	Хан-Уул	11, 17	88.5	91.8	90.1	А	Бүрэн хангалттай
10	МЭНДСАРУУЛ өэмт	Хан-Уул	15, 18, 19	91.1	90	90.5	А	Бүрэн хангалттай
11	ЭНХТИТЭМ ӨЭМТ	Хан-Уул	3, 20	93	91.8	92.4	А	Бүрэн хангалттай
12	Шэжид дүг	Чингэлтэй	12	93.3	91	92.1	А	Бүрэн хангалттай

2.94. ӨЭМТ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн аудитын байгууллагаас түүвэрлэн хяналт шалгалтыг зохион байгуулдаг бөгөөд хувийн хэвшлийн буюу нөхөрлөлийн статустай хуулийн этгээд тул тусгайлан тайлан гаргаж ӨЭМТ-дэд хүргэгддэггүй байна.

2.95. Мөн ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд харьяалах дүүргийн дотоод аудитын хэлтсээс хяналт шалгалтыг хийдэг боловч зарим дүүргийн ӨЭМТ-үүд дүүргийн дотоод аудитын хяналт шалгалтад хамрагдаагүй, хамрагдахаас татгалзсан байна. Тухайлбал: БГД-ийн дотоод аудитын албанаас 2022 онд дүүргийн ӨЭМТ-дэд санхүүгийн хяналт шалгалтыг хийхээр дүүргийн Засаг даргаар удирдамжийг батлуулсан боловч уг удирдамжийг түдгэлзүүлэх хүсэлтийг Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны Баянгол дүүргийн салбар зөвлөлөөс ирүүлсэн байна.

¹⁷ 15.30.Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг аймаг, дүүргийн Засаг дарга шууд батламжилна.

¹⁸ 5.4.Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Эрх бүхий байгууллагаас хууль тогтоомж, журамд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж байгаа ч ЭМДС-ийн санхүүжилт, нэхэмжлэлийн хасагдалтад бүрэн хяналт тавих боломжгүй, ӨЭМТ-ийн хувьд хязгаарлагдмал байна.

2.96. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Тус хуулийн 6 дугаар зүйлд заасан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан мэдээллүүдээс дурдвал дараах байдалтай байна.

Хүснэгт 22. 2021 оны шилэн дансны мэдээлэл

№	ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР	МЭДЭЭЛБЭЛ ЗОХИХ	ҮҮНЭЭС МЭДЭЭЛСЭН		МЭДЭЭЛЭЭГҮЙ	ХУГАЦАА ХОЦРООЖ МЭДЭЭЛСЭН
			Тоо	Хувь		
1	НЭМГ	-	-	-	-	105
2	ХУДЭМТ	-	-	-	-	-
3	СХДЭМТ	176	174	-	-	2
4	БГДЭМТ	801	-	-	63	-
5	ЧДЭМТ	-	-	-	-	ХУГАЦАА ХОЦРООЖ МЭДЭЭЛСЭН
6	СБДЭМТ	-	-	-	-	1
7	БЗДЭМТ	310	-	-	-	25
8	БХЭМТ	31	-	-	31	-
9	БНДЭМТ	-	-	-	-	1
10	НДЭМТ	154	151	-	-	3
11	ХУДНЭ	154	-	-	-	42
12	БЗНЭ	-	-	-	-	-
13	СХНЭ	-	-	-	-	-
14	СБНЭ	-	-	-	-	-
15	НТТТ	141	-	-	-	1
16	НАРКОЛОГИ	105	97	-	-	8
17	ЭНЭРЭЛ	-	-	-	-	-
18	НШЭНТ	-	-	-	-	-
19	УАУЭСК	-	-	-	-	-

2.97. БХДЭМТ нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 31 мэдээллүүдээс 31-ийг, БГДЭМТ 63 мэдээллийг байршуулаагүй байна.

2.98. Энэ нь НТАГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар гарсан зөрчлөөр шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалтыг зөрчсөн байна гэж үзжээ.

Хүснэгт 23. 2022 оны шилэн дансны мэдээлэл

№	ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР	МЭДЭЭЛБЭЛ ЗОХИХ	ҮҮНЭЭС МЭДЭЭЛСЭН		МЭДЭЭЛЭЭГҮЙ	ХУГАЦАА ХОЦРООЖ МЭДЭЭЛСЭН
			Тоо	Хувь		
1	НЭМГ	182	182	100%	-	-
2	ХУДЭМТ	-	-	-	20	-
3	СХДЭМТ	328	325	-	3	-
4	БГДЭМТ	759	671	-	88	-
5	ЧДЭМТ	190	185	-	5	-
6	СБДЭМТ	-	-	100%	-	-
7	БЗДЭМТ	175	168	-	4	4
8	БХЭМТ	65	41	-	24	-
9	БНДЭМТ	270	267	-	-	3
10	НДЭМТ	170	169	-	-	1
11	ХУДНЭ	119	103	-	16	-
12	БЗНЭ	-	-	-	-	-
13	СХНЭ	164	164	100%	0	-
14	СБНЭ	119	-	-	4	7
15	НТТТ	232	230	-	1	1
16	НАРКОЛОГИ	105	78	-	-	27
17	ЭНЭРЭЛ	170	156	-	-	14
18	НШЭНТ	167	113	-	-	54

2.99. НЭМГ, СБДЭМТ, СХДНЭ нь 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах мэдээллүүдийг бүрэн байршуулсан. Нийслэлийн шүд эрүү нүүрний төв нь 2022 оны тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 167 мэдээллээс 113 мэдээллийг хугацаанд байршуулж, 54 мэдээллийг хугацаа хоцроож 52 мэдээллийг байршуулаагүй, мэдээллийн дүн буруу байршуулсан байна.

2.100. БГДЭМТ- нь 2022 онд 759 мэдээллийг байршуулахаас 88 мэдээллийг ил тод байршуулаагүй, хугацаа хоцроож байршуулсан байна. БХДЭМТ-нь 2022 онд нийт 65 мэдээллийг байршуулахаас 24 мэдээллийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх заалтыг мөрдөөгүй байна.

2.101. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 болон 5.2-д заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосны дагуу НЭМГ орлогчоо чөлөөлсөн байна.

НЭМГ болон харьяа ЭМБ-ууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дээр өмнөх оны зөрчлүүд давтан гарсаар байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн аудитын түүвэрт хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудын хүрээнд дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдтэй Нийслэлийн зорилт арга хэмжээнүүд уялдаж эрүүл мэндийн даатгалын тогтолцоондоо шинэчлэлт хийж байгаа ч хэрэгжилт хангалтгүй, НЗД “Нийслэлийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г батлаагүй байна.
2. ЭМДС-ийн орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгуулах нэг иргэнээр тооцон олгох төслийг 2021, 2022 онд НЭМГ-аас албажуулан хүргүүлээгүй, ЭМДЕГ-аас 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн бүс нутгийн хүн амын тоотой уялдуулан бодитой хуваарилаагүй, эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан даатгалын гэрээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэх боломжгүй байна.
3. НЭМГ-ын хувьд цахим системээр дамжуулан иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажил нь хангалтгүй байна.
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлд тавих хяналт сул, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомж, журамд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх байдал ӨЭМТ-ийн хувьд хязгаарлагдмал, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэл Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

1. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:

1. “Нийслэлийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлэх;
2. НЭМГ болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах;

Нийслэлийн Эрүүл мэндийн газарт:

1. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах;
2. Эрүүл мэндийн салбарт ашиглаж буй цахим системийн хэрэглээг сайжруулж, иргэдийг шаардлагатай мэдээллээр ханган өргөдөл гомдлыг шийдвэрлэх;

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах асуудлыг ҮАГ-т уламжилж байна. Үүнд:

Эрүүл мэндийн яаманд /ЭМДҮЗ, ЭМДЕГ/:

1. ӨЭМТ-ийн эмч нар ангилал харгалзахгүй хөнгөлөлтэй эмийн жор бичиж байгаа асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;
2. 2022 оны 1, 2, 3 дугаар сарын санхүүжилтийг шинэчилсэн хэмжээгээр ӨЭМТ-д бүрэн хуваарилаагүй асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;
3. Анхан шатны ЭМБ-ууд ө-hospital цахим систем дээр хөнгөлөлтэй эмийн цахим жорыг бичиж байгаа хэдий ч эмчийн болон иргэний хурууны хээний баталгаажилт хийгдэхгүй байгаа асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

Хавсралт 1. Нийслэлийн харьяа ЭМБ-уудын ашиглаж буй цахим системийн жагсаалт, танилцуулга

№	Программын нэр	Танилцуулга	Хамрах хүрээ	он
1	H-info 3	Бүх шатлалын эмнэлгүүдэд эрүүл мэндийн бүртгэлийг мэдээлэх хуудсуудыг бүртгэн статистик тайлан мэдээ гаргаж илгээх зориулалт бүхий систем.	Төрөлжсөн эмнэлгүүд, аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, төрийн болон хувийн хэвшлийн ор бүхий эмнэлэг, сувилал, сум, тосгоны эрүүл мэндийн төв	2007
2	HInfo-stata	Эрүүл мэндийн статистик бүртгэл, тайлангийн систем	Эрүүл мэндийн салбарын бүх түвшний байгууллагуудын эмч, бүртгэл мэдээллийн ажилтан болон энэ талаар сургалт явуулдаг багш, суралцагч нар	2021
3	tailan.ubhealth.mn	НЭМГ-аас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг бүртгэх, эрүүл мэндийн статистикийн мэдээ тайлан авах цахим систем	НЭМГ-ын статистик мэдээ тайлан хариуцсан болон тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, НЭМГ-аас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагууд	2020
4	Ehealth программ	Төрөлжсөн болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн бүртгэл хийх эмнэлэг хооронд өвчтөний оношилгоо, шинжилгээний мэдээлэл солилцох, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх систем	Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Аймгийн нэгдсэн эмнэлгүүд ашиглаж байна.	2016
5	E-hospital программ	Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх замаар эмнэлэг хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулах	Нийслэл, аймаг сумдын Өрхийн эрүүл мэндийн төв, тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа	2022
6	https://tzmoh.gov.mn/	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгалт хийх, байршил, эзэмшигч солих бүртгэлийн цахим систем	Нийслэлийн эрүүл мэндийн газар, Аймгийн нийслэлийн эрүүл мэндийн газрууд ашиглаж байгаа	2022
7	Хүүхдийн хоол тэжээлийн дутагдлын эмчилгээний хяналтын систем	Тав хүртэлх насны хүүхэд болон шаардлагатай зорилтот бүлгийн хүүхдийн суурь өвчлөл, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, эмчлэх үйл ажиллагаанд мэдээллийн санг бүрдүүлэх цахим програм хангамж	Дүүргийн эрүүл мэндийн төв. 142 ӨЭМТөв ашиглана.	2023
8	www.tandaltv.gov.mn	Covid-19 корновирусын халдвартай иргэн болон ойрын хавьтлын бүртгэл, хяналтын систем	Нийслэл, дүүрэг, аймаг. Өрхийн эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа	2021
9	TUBIS систем	Сүрьеэгийн тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлж байгаа томоохон төсөл хөтөлбөрийн бол Глобал сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн мэдээллийн программ TUBIS систем юм.	Нийслэл, дүүрэг, аймаг. Өрхийн эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа	
10	https://dentalcenter.mn	Шүд эрүү нүүрний төвийн онлайн цаг захиалгын систем	Нийслэлийн хэмжээний хүн амд үйлчлэх	2020
11	Medsoft 7v программ	Эмнэлгийн бүртгэл хийх эмнэлэг хооронд өвчтний оношлогоо, шинжилгээний мэдээлэл солилцох, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх систем	БДНЭ, БНДЭМТ, хувийн эмнэлэг	2021
12	www.health.gov.mn	Төрөлжсөн болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн бүртгэл хийх эмнэлэг хооронд өвчтний оношлогоо, шинжилгээний мэдээллийг бүртгэн даатгалаас санхүүжилт олгох	ДЭМТ, НЭмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд	2018
13	www.health.gov.mn	Хөнгөлөлттэй эмийн жор бичих	ДЭМТ, НЭмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд	2020
14	https://vis.health.gov.mn	Иргэн вакцины хамрагдах, вакцины тунгийн мэдээлэл харах, гэрчилгээ авах программ	Монгол улсын хэмжээнд	2022
15	MNCARDIO	Лавлагаа шатны эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлэгт Люксембургийн Засгийн газрын санхүүжилттэй "Алсын зайн анагаах ухааны үндэсний сүлжээ" төсөл. Зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний систем	Лавлагаа шатны эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг	2018
16	МонПэн	Зүрх судасны нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц (МонПЭН) санаачилгын хүрээнд MNCARDIO програм хангамжийн МонПЭН эрсдэл тооцох цахим программ	Анхан шатны эмнэлэг, сумын нэгдсэн эмнэлэг	2021
17	ORBIS	ЧШХШ2 өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, эмчилгээний арга аргачлалыг сайжруулж, чихрийн шижингийн хүндрэлээс сэргийлэх замаар иргэдийн өвчлөл, хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтыг бууруулж амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.	ЧШХШ 2 өвчний оношилгоо, эмчилгээний чиглэлээр ажиллаж буй өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн хэрэглэнэ	2021

18	burtgei.mohs.mn	Коронавируст халдвар /КОВИД/-ын цар тахлын үеийн мэдээ, мэдээллийн бэлэн байдлыг хангах, нэгдсэн сан үүсгэх зорилгоор	Нийслэл, дүүрэг, аймаг. Өрхийн эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа	2021
19	eruul.gov.mn, ЭрүүлМН	Коронавируст халдвар /КОВИД/-ын цар тахлын үеийн мэдээ, мэдээллийн бэлэн байдлыг хангах, нэгдсэн сан үүсгэх зорилгоор	Нийслэл, дүүрэг, аймаг. Өрхийн эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа	2022
20	Licemed	Эмийн экспорт импортын лиценз, Бүртгэлийн үйл ажиллагаа, бүртгэгдсэн эмийн мэдээллийн сан, эмийн сангийн тайлангийн систем	Улсын болон хувийн эмнэлгийн эм ханган нийлүүлэх ХХК	
21	“Элэг бүтэн Монгол”	“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд гепатитийн вирусийн халдварын эрт илрүүлэг шинжилгээнд эрүүл мэндийн даатгалтай нийт 929129 иргэн хамрагдсан байна. Энэ нь хамрагдвал зохих 15-аас дээш насны хүн амын 60.6 хувийг эзэлж байна. Үүний зэрэгцээ эрүүл мэндийн даатгалгүй олон хүн элэгний В,С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээ, эмчилгээнд хамрагдсан байна.	Нийслэл, дүүрэг, аймаг. Өрхийн эрүүл мэндийн төвд ашиглагдаж байсан	2017
22	Screening.gov.mn	Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг бүртгэлийн программ Screening.gov.mn	Улсын хэмжээнд	2013
23	www.ewar@nccd.gov.mn	Халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлыг мэдээлэл бүртгэх, дүн шинжилгээ хийдэг программ	Улсын хэмжээнд	2008
24	LIMS-Лабораторийн мэдээллийн удирдлагын /нэгдсэн/ систем	Геологи, уул уурхайн дээжийн шинжилгээ хийдэг лабораториудад зориулагдан зохиогдсон бөгөөд ижил төрлийн шинжилгээний лабораториудад ашиглагдаж байгаа туршлагатай байх шаардлагатай. Лабораторийн мэдээллийн удирдлагын систем нь лабораторийн үйл ажиллагааг оновчтой болгон хялбарчилж дээж хүлээн авахаас үр дүн гарах хүртэлх үйл ажиллагааг бар кодоор бүртгэн дугаарлаж автоматжуулан зохицуулах программ	Улсын хэмжээнд	2020
25	https://karte.mn	Төрөлжсөн болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн бүртгэл хийх эмнэлэг хооронд өвчтөний оношилгоо, шинжилгээний мэдээлэл солилцох, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх систем	СХДНЭмнэлэг, хувийн эмнэлэг	2020
26	Eclinic.mn	Хувийн эмнэлгийн бүртгэл хийх эмнэлэг хооронд өвчтөний оношилгоо, шинжилгээний мэдээлэл солилцох, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх систем	Хувийн эмнэлэг	2020

Эх сурвалж : НЭМГ-ын статистик мэдээлэл, цахим эрүүл мэндийн хэлтэст буй программ хангамжийн танилцуулга